

**“Erasmus” төслийн Эко Ази дээд сургуулийн багийн
ээлжит онлайн хурлын тэмдэглэл**

2021 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

**ТХГН-ИЙН экосистемийн үйлчилгээний менежментийн чиглэлээр магистрын
сургалтын хөтөлбөр боловсруулах төслийн Ажлын багц /АБ1/ -ын санал
асуулгын боловсруулалт болон бусад асуудлаар**

Хурал хийсэн газар: Хурлыг google meet ашиглан meet.google.com/mde-gwuk-jmo линкээр хийлээ. Хурлыг 09:00 цагт эхэлж, 09:40 цагт дуусгав.

Хэлэлцэх асуудал: Санал асуулгад SPSS боловсруулалт хийх, зарим тоног төхөөрөмж болон судалгааны ажлын томилолтын зардалыг урьдчилан авах, тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөний талаар

Хуралд оролцсон:

ЭКО АЗИ БОМДС-ийн Ерөнхий захирал Ц.Адъяасүрэн, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр, эрдмийн зөвлөлийн гишүүн Д.Энэбиш, ахлах багш Э.Доржпагма, экологийн тэнхмийн судлаач багш А.Төмөр-Өлзий, Аргун Манлайлал ТББ-ын менежер Д.Бямбаа нар оролцов.

Хэлэлцсэн нь:

1. Э.Доржпагма: Санал асуулгын үр дүнг SPSS – ээр боловсруулахаар Аргун Манлайлал ТББ-ын Нарнаа руу файлуудыг илгээсэн байгаа. А.Эрдэнэбаяр: SPSS-ээр боловсруулалт заавал хийх шаардлагатай юмуу. Google form өөрөө схем диаграм гаргаад өгдөг байгаа. Нарнаа: Олон сонголттой асуултуудын хувьд SPSS-ээр боловсруулах нь үр дүнтэй юм. Одоо хариултуудаа кодлох хэрэгтэй байгаа.
2. Ц.Адъяасүрэн: 6 сарын 11-21 хооронд Хөгнө Тарнын БЦГ болон Улаан Тайга ТХГН-уудад уулзалт, судалгаа хийнэ. Тиймээс бидэнд томилолт болон тоног төхөөрөмжөөс яаралтай шаардлагатай байгаа компьютеруудаа түрүүлж авах зардалын талаар Төслийн олон улсын менежер Жорж руу хүсэлт гаргасан захиа бичих хэрэгтэй байна.
3. Д.Бямбаа: WP6-ын тогтвортой байдлыг хангах ажлын төлөвлөгөөний дагуу зорилтот бүлэг дээр МСҮТ-ийг нэмж оруулан тэдэнтэй хамтран ажиллах саналтай байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Санал асуулгын үр дүнгээ SPSS ашиглан боловсруулахаар болов. А.Эрдэнэбаяр болон Э.Доржпагма нар Санал асуулгын үр дүнгийн SPSS-ээр боловсруулахад 118 оролцогчийн хариултуудыг хувааж кодлож өгнө.
2. Төслийн менежер Жорж руу 2 хүсэлт /хээрийн судалгааны ажлын томилолт болон компьютеруудаа дотоодоосоо авч байх зардалыг хүссэн/ гаргасан мэйлийг орчуулж бэлтгэн албан бичиг байдлаар хүргүүлэхээр боллоо.
3. Зүүнхараа болон Сэлэнгийн МСҮТ-тэй Д.Бямбаа холбоо тогтоож багш нараас мастерт сургах асуудлаар хэлэлцэнэ. Д.Энэбиш УБ хотын “Эко Монгол” МСҮТ-ийн захирал **Л.Эрдэнэтөгстэй** холбоо тогтоож хамтран ажиллахаар болов.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.ДОРЖПАГМА

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН :

Ц.АДЪЯАСҮРЭН